

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2018 оны  
санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** САГ-2019/17/СТА-ТӨҮГ

**Агуулга**

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил .....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	8
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.8.3	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал... ..	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	100
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	100
3	Менежментийн захидал .....	11
3.1	Татвар тайлагналтай холбоотой асуудал .....	11
3.1.1	Илрүүлэлт:.....	11
3.1.2	Эрсдэл: .....	11
3.1.3	Өгсөн зөвлөмж: .....	11
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: .....	11
3.2	Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой асуудал .....	12
3.1.2	Илрүүлэлт: .....	12
3.2.2	Эрсдэл: .....	12
3.2.3	Өгсөн зөвлөмж: .....	12
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: .....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	13
4.4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан .....	14
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.5	Аудит хийсэн Зорилто түвшингийн төлөвлөгөө .....	17
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



ГЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН  
СТАНЦ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Л.ЭРХБААТАР ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/473  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г \_\_\_\_\_ Г  
Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 13-наас 2019 оны 3 дугаар сарын 5-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-д хүргүүлэхээр төлөвлөн, “Б энд С аудит” ХХК-ийн ахлах аудитор Д.Дашхорлоо, аудитор Б.Нарантуяа, Д.Заяажаргал, аудиторын туслах Б.Эрдэнэтогтох нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 15-ний өдрийн дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн үндсэн зорилт нь хэрэглэгчийг дулаан, цахилгааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 4 тоот хавсралт Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн дүрмийн 2.2-д үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:

- Цахилгаан үйлдвэрлэх
- Дулаан үйлдвэрлэх
- Дулаан түгээх
- Дулаанаар зохицуулаалалттай хангах
- Эрчим хүчний тоног төхөөрөмж
- Даралтат сав шугам хоолойг ашиглах
- Засвар үйлчилгээ хийх түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлж болно гэж тодорхойлжээ.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.



Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах “шаардлагагүй” гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Интерактив” ХХК-ийн “даймонд” програм хангамж ашигладаг байна.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.



Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 21 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын түвшинг 1 хувиар сонгов.

Энэ нь орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дансанд эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 35,471.2 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 354.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь зардлын дансанд эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 21 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 19 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

### **2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Хувь хүнээс худалдан авалт хийсэн тухай бүр Ибаримтанд шивүүлсэн боловч ХХОАТ-ын ТТ-12-т бүртгэж татварын байгууллагад хуулийн хугацаанд тайланг илгээдэггүй
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 171 ажилаас 103 ажлыг түүвэрлэж үзэхэд татварын өртэй, гэрээний бүрдэл дутуу, зарим ажил үйлчилгээнд техникийн хяналтын ажлын явцын тэмдэглэлгүй зэрэг зөрчилүүд байна.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

### 2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган

төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2		Татварын тайланг хуулийн хугацаанд нь тайлагнадаггүй, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг түүвэрлэж үзэхэд татварын өртэй, гэрээний бүрдэл дутуу, зарим ажил үйлчилгээнд техникийн хяналтын ажлын явцын тэмдэглэл байхгүй байна.
	Дүн	2		

### 2.8.3 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй болно.

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байгууллагын 2018 оны зорилтот түвшингийн төлөвлөгөөнд тусгагдсан их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний ажлуудаас 50-80 хувийн гүйцэтгэлтэй байгаа ажил, нормчлалын сан, техник хяналтын зардалд үлдсэн 598.7 сая төгрөгийг дараагийн аудитаар нягталж үзэх.

## **2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой 2018 оны эдийн засгийн үндсэн зорилтот түвшингийн төлөвлөгөөнд орлого 35,276.6 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 35,471.2 сая төгрөгийн зардал гаргаж 343.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК нь Шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт 2018 онд нийт 74 мэдээлэл оруулахаас 66 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 8 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **Татвар тайлагналтай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Хувь хүнээс худалдан авалт хийсэн тухай бүр Ибаримтанд шивүүлсэн боловч Хувь хүний орлогын албан татварын ТТ-12-т бүртгэж татварын байгууллагад хуулийн хугацаанд тайланг илгээдэггүй. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 29.1.4-д “суутгагч нь иргэнд орлого олгох бүрдээ түүний татвар төлөгчийн дугаарыг орлого олгосон тухай баримтад тэмдэглэж, иргэн бүрт олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээг тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж мэдэгдэх” гэсэн заалт хэрэгжээгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Холбогдох хууль тогтоомж зөрчигдөх

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Цаашид хуулийн хугацаанд татварт тайлагнаж байх

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

## **3.2 Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой асуудал**

### 3.2.1 Илрүүлэлт:

Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 171 ажилаас 103 ажлыг түүвэрлэж үзэхэд татварын өртэй, гэрээний бүрдэл дутуу, зарим ажил үйлчилгээнд техникийн хяналтын ажлын явцын тэмдэглэлгүй зэрэг зөрчилүүд байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.2 “Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана” гэсэн заалт хэрэгжээгүй байна.

### 3.2.2 Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомж зөрчигдөх

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулах

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 3-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	1/1/2018	12/31/2018
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,911,670,501.90	1,112,212,503.87
1.1.2	Дансны авлага	1,411,784,720.42	2,426,707,358.80
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	35,460.00	6,629,937.69
1.1.6	Бараа материал	1,990,343,965.49	2,492,097,649.39
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,378,840,205.02	794,970,040.39
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>7,692,674,852.83</b>	<b>6,832,617,490.14</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	33,946,171,491.51	59,738,632,080.13
1.2.2	Биет бус хөрөнгө	6,276,692.65	20,955,499,894.09
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>33,952,448,184.16</b>	<b>80,694,131,974.22</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>41,645,123,036.99</b>	<b>87,526,749,464.36</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	215,037,290.59	123,283,060.64
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,457,464,180.36	1,583,476,274.56
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	47,092,765.70	6,884,955.66
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,719,594,236.65</b>	<b>1,713,644,290.86</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	61,951.78	40,217,483.23
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>61,951.78</b>	<b>40,217,483.23</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,719,656,188.43</b>	<b>1,753,861,774.09</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	19,447,456,792.53	19,447,456,792.53
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	34,360,784,468.64	59,135,050,898.37
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		20,734,205,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-13,882,774,412.61	-13,543,825,000.63
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>39,925,466,848.56</b>	<b>85,772,887,690.27</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>41,645,123,036.99</b>	<b>87,526,749,464.36</b>

#### 4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>34,372,143,333.12</b>	<b>35,366,842,042.38</b>
2	Борлуулалтын өртөг	31,377,290,287.85	31,741,035,862.41
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>2,994,853,045.27</b>	<b>3,625,806,179.97</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	65,733,594.72	147,494,342.37
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	319,688,807.70	354,822,746.02
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,823,499,610.46	2,838,943,974.12
10	Ерөнхий ба удирдлагын зардал	281,553,749.20	701,160,401.56
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	219,188,684.92	190,074,563.31
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>56,033,403.11</b>	<b>398,862,329.37</b>
19	Орлогын татварын зардал	6,573,359.48	54,966,917.39
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>49,460,043.63</b>	<b>343,895,411.98</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>49,460,043.63</b>	<b>343,895,411.98</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>49,460,043.63</b>	<b>343,895,411.98</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		



### 4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<b>19,447,456,792.53</b>	<b>34,360,784,468.64</b>		<b>-13,917,330,906.24</b>	<b>39,890,910,354.93</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл	19,447,456,792.53	34,360,784,468.64		-13,917,330,906.24	39,890,910,354.93
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				49,460,043.63	49,460,043.63
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт				-14,903,550.00	-14,903,550.00
7	Зарласан ногдол ашиг					
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	<b>19,447,456,792.53</b>	<b>34,360,784,468.64</b>		<b>-13,882,774,412.61</b>	<b>39,925,466,848.56</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл	19,447,456,792.53	34,360,784,468.64		-13,882,774,412.61	39,925,466,848.56
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				343,895,411.98	343,895,411.98
13	Бусад дэлгэрэнгүй орлого			20,734,205,000.00		20,734,205,000.00
14	Өмчид гарсан өөрчлөлт					
15	Зарласан ногдол ашиг				-4,946,000.00	-4,946,000.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		24,774,266,429.73			24,774,266,429.73
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	<b>19,447,456,792.53</b>	<b>59,135,050,898.37</b>	<b>20,734,205,000.00</b>	<b>-13,543,825,000.63</b>	<b>85,772,887,690.27</b>

#### 4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>30,368,510,367.66</b>	<b>33,410,459,324.24</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	30,551,902,405.19	33,253,002,999.01
1.1.6	Бусад мөнгөн орлого	86,607,962.47	157,456,325.23
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>27,839,321,235.05</b>	<b>29,503,518,105.41</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	6,373,282,780.14	6,924,539,806.79
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,874,869,954.70	2,176,533,450.45
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	11,449,000,000.00	12,099,025,965.62
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,995,433,202.02	1,581,257,733.03
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,266,395,513.90	4,684,492,153.42
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,843,550,492.51	1,992,065,265.99
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	6,851,433.00	7,768,611.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	29,937,858.78	37,835,119.11
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>2,799,189,132.61</b>	<b>3,906,941,218.83</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>65,733,594.72</b>	<b>147,494,342.37</b>
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	65,733,594.72	147,494,342.37
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,532,538,752.45</b>	<b>4,848,947,559.23</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,530,651,152.45	4,623,247,186.03
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,887,600.00	225,700,373.20
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-2,466,805,157.73</b>	<b>-4,701,453,216.86</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>30,700,000.00</b>	
3.1.3	Төрөл бүрийн хандив	30,700,000.00	
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>14,903,550.00</b>	<b>4,946,000.00</b>
3.2.4	Төлсөн ногдол ашиг	14,903,550.00	4,946,000.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>15,796,450.00</b>	<b>-4,946,000.00</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>		
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>348,180,424.88</b>	<b>-799,457,998.03</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,563,490,077.02</b>	<b>1,911,670,501.90</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,911,670,501.90</b>	<b>1,112,212,503.87</b>

**4.5 Аудит хийсэн 2018 оны жилийн зорилтот түвшингийн төлөвлөгөө**

(төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 оны төлөвлөгөө	2018 оны гүйцэтгэл	зөрүү
1	ЦЭХ боловсруулалт	мян.квт	156,141.0	163,885.6	7,744.6
2	ДЭХ боловсруулалт	гкал	571,808.0	592,399.0	20,591.0
3	ДХЦЭХ	мян.квт	30,609.0	31,043.3	434.3
5	ДХЦЭХ хувь	%	19.60%	18.94%	-0.66%
4	ЦЭХ түгээлт	мян.квт	125,532.0	132,842.3	7,310.3
6	ДЭХ түгээлт	гкал	545,405.0	567,210.0	21,805.0
7	ЦЭХ-ний зардал	мян.төг	18,252,775.5	18,217,051.8	(35,723.6)
8	ЦЭХ-ний орлого	мян.төг	26,704,085.6	26,722,329.0	18,243.4
9	<b>ЦЭХ-ний ашиг алдагдал</b>	мян.төг	<b>8,451,310.1</b>	<b>8,505,277.2</b>	53,967.1
10	ДЭХ-ний зардал	мян.төг	16,260,450.1	16,135,798.3	(124,651.8)
11	ДЭХ-ний орлого	мян.төг	8,572,473.3	8,644,512.8	72,039.5
12	<b>ДЭХ-ний ашиг алдагдал</b>	мян.төг	<b>(7,687,976.8)</b>	<b>(7,491,285.4)</b>	196,691.3
13	<b>Нийт орлого</b>	мян.төг	<b>35,276,558.9</b>	<b>35,366,841.9</b>	90,283.0
14	Нийт зардал	мян.төг	<b>34,513,225.6</b>	<b>34,352,850.1</b>	(160,375.5)
15	Ажил.дын нийгмийн зард	мян.төг	931,032.2	928,289.9	(2,742.3)
16	<b>Бүгд зардал</b>	мян.төг	<b>35,444,257.8</b>	<b>35,281,140.0</b>	(163,117.8)
17	<b>үйлд ашиг алдагдал</b>	<b>мян.төг</b>	<b>(167,698.9)</b>	<b>85,701.9</b>	253,400.8
18	Үйлдв. бус орлого	мян.төг	381,274.0	503,235.1	121,961.1
19	Үйлдв. Бус зардал	мян.төг	202,562.7	190,074.6	(12,488.1)
20	<b>үйлд бус ашиг алдагдал</b>	<b>мян.төг</b>	178,711.3	313,160.5	134,449.2
21	<b>Татварын зардал ТХХ</b>	<b>мян.төг</b>	<b>11,012.4</b>	<b>14,749.4</b>	3,737.0
22	<b>Ашиг алдагдал</b>	<b>мян.төг</b>	<b>(0.0)</b>	<b>384,112.9</b>	384,113.0
23	ЦЭХ-ний өртөг	төг/квт	145.40	137.13	(8.27)
24	ЦЭХ-ний үнэ	төг/квт	212.73	201.16	(11.57)
25	ДЭХ-ний өртөг	төг/гкал	29,813.53	28,447.66	(1,365.87)
26	ДЭХ-ний үнэ	төг/гкал	15,717.63	15,240.41	(477.22)
27	1Квт ЦЭХ-нээс олсон ашиг	төг/квт	67.32	64.03	(3.30)
28	1Гкал ДЭХ-нээс алдагдал	төг/гкал	(14,095.90)	(13,207.25)	888.65

## 5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2019.03.05</b>	Аудитын нэр: <b>Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>САГ-2019/17/СТА-ТӨҮГ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨҮГ</b>	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Хувь хүнээс худалдан авалт хийсэн тухай бүр Ибаримтанд шивүүлсэн боловч ХХОАТ-ын ТТ-12-т бүртгэж татварын байгууллагад хуулийн хугацаанд тайланг илгээдэггүй	0	Менежментийн захидлаар зөвлөмж өгөх	Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга	Ч.Орхон
2	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 171 ажилаас 103 ажлыг түүвэрлэж үзэхэд татварын өртэй, гэрээний бүрдэл дутуу, зарим ажил үйлчилгээнд техникийн хяналтын ажлын явцын тэмдэглэлгүй зэрэг зөрчилүүд байна.	0	Менежментийн захидлаар зөвлөмж өгөх	Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга	Ч.Орхон
	<b>Дүн</b>	<b>0</b>			

